



МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ХООРОНД ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАЛААР ЭРХ ЗҮЙН ТУСЛАЛЦАА ХАРИЛЦАН ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс /цаашид "Талууд" гэнэ/,

Эрүүгийн хэргийн салбарт хамтран ажиллаж, эрх зүйн талаар харилцан туслалцаа үзүүлэх замаар хоёр улсад эрүүгийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, ял шийтгэх болон таслан зогсоох үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлхийг эрмэлзэн,

дараах зүйлийг хэлэлцэн тохиров. Үүнд:

1 дүгээр зүйл Гэрээний үйлчлэх хүрээ

1. Талууд эрүүгийн хэргийг мөрдөн байцаах, ял шийтгэх болон таслан зогсоох үйл ажиллагаанд энэхүү Гэрээний заалтуудын дагуу харилцан туслалцаа үзүүлэх арга хэмжээ авна.

2. Энэхүү Гэрээний зорилгоор, эрүүгийн хэрэг гэдэгт Хүсэлт гаргагч Талаас мөрдөн байцаах, ял шийтгэх болон шүүн таслах ажиллагаатай холбогдуулан туслалцаа үзүүлэх тухай хүсэлт гаргах үед, тухайн туслалцаа үзүүлэхийг хүссэн гэмт хэргийн ял шийтгэл нь Хүсэлт гаргагч Талын хуулийн эрх бүхий байгууллагын хэргийн харьяалалд орсон гэмт хэргийг хэлнэ.

3. Туслалцаанд дор дурьдсан зүйлийг хамруулна. Үүнд:

а/ аливаа этгээдээс нотлох баримт болон мэдүүлэг авах;

б/ мэдээлэл, бичиг баримт, хэргийн материал, эд зүйлийг өгөх;

в/ аливаа этгээд, эсхүл эд зүйлийн байршлийг тогтоох, тэдгээрийг танин тогтоох;

г/ шүүхийн бичиг баримт гардуулах;

д/ нэгжих болон эд зүйл хураан авах тухай хүсэлтийг биелүүлэх;

е/ саатуулагдсан этгээд болон бусад этгээдүүдээр мэдүүлэг өгүүлэх, эсхүл тэдгээрийг мөрдөн байцаах үйл ажиллагаанд туслалцуулах;

ё/ гэмт хэргийн улмаас олсон эд зүйлийн талаар туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах;

ж/ Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжоор хориглоогүй бусад хэлбэрийн туслалцаа үзүүлэх.



4. Энэхүү Гэрээ нь дор дурьдсан зүйлд хамаарахгүй. Үүнд:

а/ гэмт этгээдийг шилжүүлэн өгөх;

б/ Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд Хүсэлт гаргагч Талын гаргасан эрүүгийн шүүхийн шийдвэрийг Хүсэлт хүлээн авагч Талд биелүүлэх;

в/ хоригдлыг ял эдлүүлэхээр шилжүүлэн өгөх;

г/ эрүүгийн гэмт хэргийн шүүн таслах ажиллагааг шилжүүлэх.

2 дугаар зүйл Бусад тохиролцоо

Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд бусад гэрээ хэлэлцээр, тохиролцоо болон аливаа өөр хэлбэрээр хүлээсэн үүрэгт нөлөөлөхгүй бөгөөд мөн бусад гэрээ хэлэлцээр, тохиролцоо болон аливаа өөр хэлбэрээр хүлээсэн үүргийн дагуу харилцан туслалцах, ийм туслалцааг үргэлжлүүлэн үзүүлэхэд саад болохгүй.

3 дугаар зүйл Эрх бүхий төв байгууллага

1. Энэхүү Гэрээний зорилгоор хүсэлт гаргах, эсхүл хүсэлт хүлээн авах эрх бүхий Төв байгууллагыг Тал тус бүр томилно. Монгол Улсын эрх бүхий Төв байгууллага нь Монгол Улсын Хууль зүйн Яам байна. Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх бүхий Төв байгууллага нь Хууль зүйн яамны сайд, эсхүл сайдын томилсон албан хүн байна.

2. Энэхүү Гэрээний зорилгоор, эрх бүхий Төв байгууллага нь дипломат шугамаар дамжуулан, эсхүл шууд харилцана.

4 дүгээр зүйл Туслалцаа үзүүлэхээс татгалзах, эсхүл хойшлуулах

1. Хүсэлт хүлээн авагч Тал дорхи үндэслэлээр туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно. Үүнд:

а/ тухайн хүсэлт нь улс төрийн гэмт хэрэгт хамааралтай, эсхүл энгийн эрүүгийн гэмт хэрэгт холбогдолгүй, цэргийн гэмт хэрэгт хамааралтай бол;

б/ хүсэлтийг биелүүлэх нь тухайн улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал болон нийгмийн хэв журам, эсхүл олон нийтийн үндсэн эрх ашигт хохирол учруулахаар бол;

в/ туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт нь тухайн этгээдийг арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, иргэний харьяалал, эсхүл улс төрийн үзэл бодлоор нь шүүн таслах, эсхүл шийтгэх гэж буй, эсхүл тухайн этгээдийн эрх ашгийг дээрхи аль нэг шалтаагаанаар хохироох гэж буй хэмээн үзэх хангалттай үндэслэлтэй бол;



г/ Хүсэлт гаргагч Талаас мөрдөн байцаалт, ял шийтгэл, эсхүл шүүн таслах ажиллагаа явуулах гэмт хэрэг нь Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжоор гэмт хэрэгт тооцогддоггүй бол.

2. Тухайн хүсэлтийг биелүүлэх нь Хүсэлт хүлээн авагч Талын явуулж буй мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоор бол Хүсэлт хүлээн авагч Тал туслалцаа үзүүлэхийг хойшшуулж болно.

3. Хүсэлт хүлээн авагч Тал аливаа хүсэлтийг татгалзах, эсхүл хойшлуулахаасаа өмнө, өөрийн шаардлагатай хэмээн үзсэн дээрхи нөхцөлүүдийн аль нэгний үндсэн дээр туслалцаа үзүүлж болох эсэх талаар Хүсэлт гаргагч Талтай зөвлөлдөнө. Хэрэв Хүсэлт гаргагч Тал энэ нөхцөлийн үндсэн дээр туслалцааг хүлээн авахыг зөвшөөрвөл энэ дагуу туслалцаа үзүүлднэ.

4. Хүсэлт хүлээн авагч Тал туслалцаа үзүүлэхээс татгалзах, эсхүл хойшлуулбал ийнхүү татгалзсан, эсхүл хойшлуулсан тухай шалтгаанаа Хүсэлт гаргагч Талд мэдэгдэнэ.

5 дугаар зүйл Хүсэлтийн агуулга

1. Туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтэд дараах зүйлийг тусгана. Үүнд:

а/ тухайн хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах, эсхүл шүүн таслах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын нэр;

б/ хүсэлтийн зорилго болон үзүүлэх туслалцааны талаархи тодорхойлолт;

в/ тухайн хэргийн тодорхойлолт болон мөрдөн байцаалт, эсхүл шүүн таслах ажиллагааны хэлбэр болон бичиг баримт гардуулахаас бусад холбогдох баримт, хууль тогтоомжийн талаархи товч танилцуулга;

г/ тухайн хүсэлтийг биелүүлж дуусгахыг хүссэн цаг хугацааны хязгаарлалт.

2. Туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтэд тухайн хүсэлтийн шаардлага, бололцооноос хамааран дараах зүйлсийг тусгана. Үүнд:

а/ нотлох баримт авах шаардлагатай этгээдийн шинж тэмдэг, иргэний харьяалал, байршил;

б/ бичиг баримт гардуулах этгээдийн шинж тэмдэг, байршил, тухайн этгээд шүүн таслах ажиллагаатай холбогдсон байдал, бичиг баримтыг хэрхэн гүйцэтгэхтэй холбогдсон мэдээлэл;

в/ эрэн сурвалжилгах этгээдийн шинж тэмдэг, байгаа газрын талаархи мэдээлэл;

г/ нэгжих газар болон хураан авах эд зүйлсийн талаархи тодорхойлолт;

д/ хүсэлтийг биелүүлэхэд дагаж мөрдөх онцгой журам, шаардлага;



е/ Хүсэлт гаргагч Талд биеэр байлцах этгээдийн зардал болон авбал зохих амьжиргааны зардлын талаархи мэдээлэл;

ё/ нууцлалыг хадгалах шаардлага бий эсэх, хэрэв тийм бол түүний шалтгаан;

ж/ хүсэлтийг зохих ёсоор биелүүлэхэд шаардагдах бусад мэдээлэл.

3. Хэрэв хүсэлтэд дурьдагдсан мэдээлэл тухайн хүсэлтийг биелүүлэхэд хангалтгүй байна хэмээн үзнэл Хүсэлт хүлээн авагч Тал нэмэлт мэдээлэл хүсч болно.

4. Онц яаралтай тохиолдолд, Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтийг аливаа бусад хэлбэрээр хүлээн авахаа зөвшөөрсөноос бусад тохиолдолд, хүсэлтийг бичгээр гаргана. Ийм онц яаралтай тохиолдолд, Хүсэлт хүлээн авагч Тал өөрөөр зөвшөөрөөгүй бол, хүсэлтийг зохих ёсны дагуу бичгээр үйлдэн дараагаар нь олгоно.

5. Энэхүү Гэрээний дагуу гаргаж буй хүсэлт, түүнийг дагалдах бичиг баримт болон бусад харилцаа нь Хүсэлт хүлээн авагч Талын хэл, эсхүл англи хэл дээр үйлдэгдсэн байна.

6 дугаар зүйл Хүсэлтийг биелүүлэх

Туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу нэн даруй биелүүлж, хэрэв энэ нь дотоодын аливаа хууль тогтоомжоор хориглоогүй бол Хүсэлт гаргагч Талын хүсэлтэд дурьдсаны дагуу гүйцэтгэнэ.

7 дугаар зүйл Хүсэлт хүлээн авагч талд эд материал эргүүлэн өгөх

Хүсэлт гаргагч Тал нь энэхүү Гэрээний дагуу шилжүүлэн өгсөн материалыг хэрэв Хүсэлт хүлээн авагч Тал ийнхүү хүсвэл, нэн даруй буцаан өгнө.

8 дугаар зүйл Нууц хадгалалт

Хүсэлт хүлээн авагч Тал, хэрэв нөгөө Тал ийнхүү хүссэн бол тухайн хүсэлт болон түүний агуулга, холбогдох бусад бичиг баримт, мөн хүсэлтийн дагуу авсан арга хэмжээний талаархи нууцлалыг чандлан хадгална. Хэрэв хүсэлтийг биелүүлэхдээ түүний нууцлалыг задруулалгүйгээр биелүүлэх боломжгүй бол, Хүсэлт хүлээн авагч Тал энэ тухай Хүсэлт гаргагч талд мэдэгдэж, Хүсэлт гаргагч Тал нь тухайн хүсэлтийг үргэлжлүүлэн биелүүлэх эсэхийг шийднэ.

9 дүгээр зүйл Хязгаарлалт

1. Хүсэлт гаргагч Тал энэхүү Гэрээний хүрээнд авсан аливаа мэдээлэл болон нотлох баримтыг тухайн хүсэлтэд тайлбарласнаас өөр мөрдөн байцаалт, ял шийтгэл болон шүүн таслах ажиллагаанд Хүсэлт хүлээн авагч Талын урьдчилсан зөвшөөрөлгүйгээр ашиглахгүй.



2. Хүсэлт гаргагч Тал нь, Хүсэлт хүлээн авагч Талаас өгсөн нууц мэдээлэл болон нотлох баримтыг зөвхөн хүсэлтэд тодорхойлсон мөрдөн байцаалт болон шүүн таслах ажиллагаанд шаардагдах хүрээнд байлгаж, мэдээлэл болон нотлох баримтын нууцлалыг, хэрэв нөгөө Тал ийнхүү хүсвэл чандлан хадгална.

3. Энэхүү Зүйлийн 1 ба 2 дугаар заалтад дурьдсан мэдээлэл болон нотлох баримт нь Хүсэлт гаргагч Талын олон нийтэд ил болсон бол ийм мэдээлэл, нотлох баримт зэргийг аливаа бусад зорилгоор ашиглаж болно.

10 дугаар зүйл Нотлох баримт авах

1. Хүсэлт хүлээн авагч Тал, хүсэлт хүлээн авмагц, өөрийн хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдүүдээс гэрчийн мэдүүлэг, эсхүл мэдүүлэг авах, эсхүл тэдгээрээр эд мөрийн нотлох баримт зэргийг Хүсэлт гаргагч Талд шилжүүлэн өгөх зорилгоор гаргуулан авна.

2. Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлтэд дурьдлагдсан этгээдүүдийг, хүсэлтийг биелүүлэх хугацаанд биечлэн байлцуулах зөвшөөрөл олгож, дээрхи этгээдүүдийг гэрчийн мэдүүлэг болон нотлох баримт өгч буй этгээдээс асуулт асуухыг зөвшөөрнө. Ийнхүү шууд асуулт асуухыг зөвшөөрөөгүй тохиолдолд, дээрхи этгээдүүдийг гэрчийн мэдүүлэг болон нотлох баримт гарган өгч буй этгээдэд асуултаа дамжуулан тавих зөвшөөрөл олгоно.

3. Энэхүү Зүйлд заасны дагуу Хүсэлт хүлээн авагч Талд хүрэлцэн очиж нотлох баримт гарган өгөх шаардлагатай этгээд нь, хэрэв Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжид тухайн этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талаас үүссэн яллан шийтгэх ажиллагааны ижил төстэй нөхцөлд нотлох баримт өгөхгүй байхыг зөвшөөрсөн бол нотлох баримт гарган өгөхөөс тагалзаж болно.

4. Хэрэв энэхүү Зүйлд заасны дагуу Хүсэлт хүлээн авагч Талд хүрэлцэн очиж нотлох баримт гаргаж өгөх шаардлагатай этгээд нь Хүсэлт гаргагч Талын хууль тогтоомжийн дагуу нотлох баримт өгөхөөс татгалзах эрхтэй хэмээн шаардвал Хүсэлт хүлээн авагч Тал нь:

а/ Хүсэлт гаргагч Талын хууль тогтоомжоор ийм эрх олгогддог эсхийг батлах талаар хүсэлт тавих; эсхүл,

б/ тухайн этгээдийг нотлох баримт гаргаж өгөхийг шаардан, тухайн нотлох баримтыг Хүсэлт хүлээн авагч Талд тухайн этгээдийн шаардаж буй эрх байдаг эсхийг тодруулахаар шилжүүлэн өгнө.

5. Хүсэлт хүлээн авагч Тал нь Хүсэлт гаргагч Талаас тухайн этгээдийн шаардаж буй эрх байдгийг нотолсон баталгаа хүлээн авсан бөгөөд үүний эсрэг өөр аливаа баталгаа үгүй бол энэхүү баталгаа нь дээрхи эрх байдгийг нотолсон хангалттай баталгаа болно.



11 дүгээр зүйл
Нотлох баримт гаргаж өгөх, мөрдөн
байцаалтад туслалцуулах этгээдийг биечлэн байлцуулах

1. Хүсэлт гаргагч Тал гэрчлүүлэх, эсхүл шүүн таслах ажиллагаа болон мөрдөн байцаалтад туслалцуулах зорилгоор аль нэг этгээд, эсхүл шинжээчийг урин ирүүлэх талаар Хүсэлт хүлээн авагч Талаас туслалцаа үзүүлэхийг хүсч болно. Хүсэлт гаргагч Тал тухайн этгээдэд олгогдох зардал болон амьжиргааны зардлын хэмжээг тодорхойлон зааж өгнө.
2. Хүсэлт хүлээн авагч Тал тухайн этгээд зөвшөөрсөн эсэх талаар Хүсэлт гаргагч Талд зохих журмын дагуу хариу мэдэгдэнэ.

12 дугаар зүйл
Нотлох баримт гарган өгөх, мөрдөн байцаалтад
туслалцуулах зорилгоор хоригдож буй этгээдийг байлцуулах

1. Хүсэлт хүлээн авагч Талд хоригдож буй этгээдийг, Хүсэлт гаргагч Талын хүсэлт мөн тухайн этгээд болон Хүсэлт хүлээн авагч Талын зөвшөөрлийн үндсэн дээр мөрдөн байцаалт болон шүүн таслах ажиллагаанд туслалцуулах зорилгоор Хүсэлт гаргагч Талд түр хугацаагаар шилжүүлэн өгч болно.
2. Тухайн шилжүүлэн өгч буй этгээдийг Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжийн дагуу хорионд байлгах шаардлагатай бол Хүсэлт гаргагч Тал тухайн этгээдийг хорионд байлгах бөгөөд тухайн хүсэлтийг биелүүлж дууссаны дараагаар хоригдож буй этгээдийг буцааж өгнө.
3. Хүсэлт хүлээн авагч Тал ийнхүү шилжүүлэн өгч буй этгээдийг хорионд байлгах шаардлаггүй хэмээн Хүсэлт гаргагч Талд мэдэгдсэн бол тухайн этгээдийг чөлөөтэй байлгах бөгөөд 11 дүгээр Зүйлд заасан этгээдийн нэгэн адил харьцана.
4. Энэхүү Зүйлд заасны дагуу шилжүүлэн өгч буй этгээдийг Хүсэлт гаргагч Талын хорионд байлгасан хугацааг Хүсэлт хүлээн авагч Талд ял эдэлж байсан хугацаанд нь оруулан тооцно.

13 дугаар зүйл
Баталгаа гаргах

1. 11 болон 12 дугаар Зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийн дагуу Хүсэлт гаргагч Талд биеэр байлцсан аливаа этгээдийг яллан шийтгэх, саатуулах, эсхүл тухайн Талд хувийн эрх чөлөөг нь бусад хэлбэрээр хязгаарлан хориглох, эсхүл Хүсэлт хүлээн авагч Талаас гарах болон аливаа үйлдэл, эс үйлдлийнхээ талаар тухайн этгээд нь хүсэлтэд дурьдсанаас өөр шүүн таслах ажиллагаанд нотлох баримт гарган өгөх, бусад мөрдөн байцаах ажилд туслалцаа үзүүлэх үүрэг хүлээхгүй.
2. Аливаа этгээдийг биечлэн байлцах шаардлаггүй хэмээн албан ёсоор мэдэгдсэнээс хойш тухайн этгээд нь 15 хоногийн хугацаанд Хүсэлт гаргагч Талаас ийнхүү гарч явах нь чөлөөтэй байсан боловч гарч яваагүй, эсхүл гарч явсан боловч сайн дураар буцан ирсэн тохиолдолд энэхүү Зүйлийн 1 дүгээр заалт үйлчилэхгүй.
3. 11 болон 12 дугаар Зүйлийн дагуу гаргасан хүсэлтэд дурьдсаныг хүлээн зөвшөөрөөгүй аливаа этгээд нь хүсэлтэд дурьдсан болон шүүхэд эсрэг мэдүүлэг



өгснийхөө төлөө ямар нэг шалтгаанаар шийтгэл хүлээх, аливаа албадлагын арга хэмжээ авахуулах зэрэг хариуцлага хүлээхгүй.

14 дүгээр зүйл

Нийтэд нээлттэй байх албан ёсны бичиг баримт

1. Хүсэлт хүлээн авагч Тал олон нийтийн бүртгэл болон бусад зорилгоор, эсхүл олон нийтэд зориулан худалдаалах зорилго бүхий нийтэд нээлттэй бичиг баримт болон хэргийн материалын хуулбарыг өгч байна.

2. Хүсэлт хүлээн авагч Тал аливаа албан ёсны бичиг баримт болон хэргийн материалын хуулбарыг өөрийн хууль тогтоомж болон хуулийн байгууллагаас тавьдаг нөхцөлийн дагуу дээрх бичиг баримтын хуулбарыг өгнө. Хүсэлт хүлээн авагч Тал энэхүү заалтыг бүхэлд нь, эсхүл хэсэгчилэн татгалзах эсэхээ өөрөө шийдвэрлэнэ.

15 дугаар зүйл

Шүүхийн бичиг баримт гардуулах

1. Хүсэлт хүлээн авагч Тал, шүүхийн зарлан дуудах гардуулах зорилгоор Хүсэлт гаргагч Талаас шилжүүлэн өгсөн бичиг баримтийг хүчин төгөлдөр болгон хэрэгжүүлнэ.

2. Аль нэг этгээдийг хүрэлцэн ирэхийг шаардсан зарлан дуудахыг гардуулах тухай хүсэлтийг тухайн этгээд хүрэлцэн ирсэн байх ёстой өдрөөс дөчин тав /45/ хоногийн өмнө Хүсэлт хүлээн авагч Тал хүлээн авсан байна. Яаралтай тохиолдолд, Хүсэлт хүлээн авагч Тал энэхүү шаардлагаас татгалзаж болно.

3. Хүсэлт хүлээн авагч Тал дээрхи зарлан дуудахыг гардуулан өгсөн тухай нотолгоог өгсөн өдөр, газар болон хэрхэн гардуулсан талаархи тайлбарын хамтаар гардуулан өгсөн эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг дарж, гарын үсэг зуран Хүсэлт гаргагч Талд илгээнэ. Хэрэв ийнхүү гардуулан өгөхийг хүчин төгөлдөр болгон хэрэгжүүлж чадаагүй бол энэ тухайгаа мэдэгдэж, шалтгааныг заана.

16 дугаар зүйл

Нэгжлэг хийх, эд зүйл хураах

1. Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн хүрээнд, Хүсэлт гаргагч Талаас нэгжлэг хийх, эд зүйлс хураан авах болон Хүсэлт гаргагч Талд шилжүүлэн өгөх тухай аливаа хүсэлтийг Хүсэлт гаргагч тухайн Талын хууль тогтоомжоор ийм үйлдлийг зөвшөөрөгддөг тухай хүсэлтэд дурьдсан мэдээллийн үндсэн дээр гүйцэтгэнэ.

2. Хүсэлт хүлээн авагч Тал нэгжлэг хийсэн, эд зүйлс хураан авсан газар, хэрхэн хураан авсан нөхцөл байдлын тухай болон хураан авсан эд зүйлсийг битүүмжилсэн талаар, хэрэв Хүсэлт гаргагч Тал хүсвэл тухайн Талд мэдэгдэнэ.

3. Хүсэлт хүлээн авагч Тал шилжүүлэн өгөх эд материалтай холбогдолтой аливаа гуравдагч этгээдийн сонирхолыг хамгаалах үүднээс шаардлагатай гэж үзсэн аливаа болзол нөхцөлийг хүлээн зөвшөөрөхийг Хүсэлт гаргагч Талаас хүсч болно.



17 дугаар зүйл Гэмт хэргийн улмаас олсон эд зүйл

1. Хүсэлт хүлээн авагч Тал хүсэлт хүлээн авмагч өөрийн хэргийн харьяалалд гэмт хэргийн улмаас олсон эд зүйл байгаа эсхийг нягтлан тодруулж, ийнхүү шалган үзсэн үр дүнгийн талаар Хүсэлт гаргагч Талд мэдэгдэнэ. Хүсэлт гаргагч Тал хүсэлт гаргахдаа хэргийн харьяалалд ийм эд зүйл байгаа гэж үзсэн өөрийн үндэслэлээ Хүсэлт хүлээн авагч Талд мэдэгдэнэ.
2. Дээрхи нэгдүгээр заалтад заасны дагуу гэмт хэргийн улмаас олсон хэмээн сэжиглэгдэж буй эд зүйл байгаа нь тогтоогдвол, Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу ийм эд зүйлийг битүүмжлэх болон хураан авах арга хэмжээ авна.
3. Энэхүү Зүйлийг хэрэгжүүлэхдээ үнэнч шударга үйл ажиллагаа явуулж буй аливаа гуравдагч этгээдийн эрхийг Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжийн хүрээнд хүндэтгэж байна.
4. Хүсэлт хүлээн авагч Тал хяналтадаа байлгаж буй хураагдсан эд зүйлийг өөрийн хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ. Хүсэлт хүлээн авагч Тал өөрийн хууль тогтоомжийн дагуу болон зүй зохистой хэмээн үзсэн нөхцөлийн үндсэн дээр хураагдсан эд зүйлийг Хүсэлт гаргагч Талд шилжүүлэн өгч болно.

18 дугаар зүйл Гэрчилгээ болон дахин баталгаажуулалт

1. Дор дурьдсан 2 дугаар заалтын дагуу туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлт, түүнийг дагалдах бичиг баримт болон эчэхүү хүсэлтийн дагуу өгсөн бусад бичиг баримт, материал зэрэгт аливаа төрлийн гэрчилгээ болон эдгээрийн эх хувийг нотолсон баталгаажуулалтыг шаардахгүй.
2. Хүсэлт хүлээн авагч Талын хууль тогтоомжинд хориглоогүй бол аливаа бичиг баримт, хэргийн материал болон бусад холбогдох материалыг хүсэлт гаргагч Талын хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс Хүсэлт гаргагч Талын хүсэлтэд дурьдсан хэлбэр, эсхүд ийм хэлбэртэй болохыг баталсан гэрчилгээг дагалдуулан шилжүүлдэг.

19 дүгээр зүйл Зардал

1. Хүсэлт хүлээн авагч Тал нь туслалцаа үзүүлэхийг хүссэн хүсэлтийг биелүүлэхтэй холбогдох зардлыг хариуцах бөгөөд Хүсэлт гаргагч Тал нь дор дурьдсан зардлыг хариуцана. Үүнд:
 - а/ Хүсэлт гаргагч Талын хүсэлтээр Хүсэлт хүлээн авагч Талын нутаг дэвсгэрээс тухай этгээдийг шилжүүлэн ирүүлэх болон буцаах зардал, 11, 12 Зүйлийн дагуу Хүсэлт гаргагч Талд биечлэн байлцах хугацаанд тухайн этгээдэд төлбөр зохих амьжиргааны зардал;
 - б/ шинжээчдийн холбогдох зардал, тэдгээрийн төлбөр.



2. Хэрэв хүсэлтийг биелүүлэхтэй холбогдсон зардалд үлэмж их хэмжээний зардал шаарлагдахаар бол Талууд тухайн хүсэлтийг ямар болзол, нөхцөлийн дагуу хэрэгжүүлэхийг зөвлөлдөн тодорхойлно.

**20 дугаар зүйл
Зөвлөлдөх**

Аль нэг Тал хүсэлт гаргавал Талууд энэхүү Гэрээг тайлбарлах, түүний үйлчлэх хүрээ болон хэрэгжүүлэлтийн талаар нэн даруй зөвлөлдөж байна.

**21 дүгээр зүйл
Хүчин төгөлдөр болох, цуцлах**

1. Энэхүү Гэрээг соёрхон батлана. Энэхүү Гэрээ нь түүнийг соёрхон баталсан тухай Батламж жуух бичгийг солилцсоноор хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Гэрээ нь хүчин төгөлдөр болсоноор, аль нэг хүсэлтийн холбогдох үйлдэл, эс үйлдэл нь энэхүү Гэрээг хүчинтэй болоогүй байхад үүсэн гарсан зэргээс үл хамааран, бүхий л хүсэлтэд үйлчилнэ.

3. Аль нэг Тал нөгөө Талдаа бичгээр мэдэгдэн энэхүү Гэрээг хэдийд ч цуцалж болно. Ийнхүү мэдэгдсэнээс хойш зургаан сарын дараа энэхүү Гэрээ хүчингүй болно.

ДЭЭРХИЙГ НОТЛОН тус тусын Засгийн газраас зохих ёсны эрх олгогдсон дараах хүмүүс энэхүү Гэрээнд гарын үсэг зурав.

Энэхүү Гэрээг Улаанбаатар хотноо, 1999 оны 5 дугаар сарын 31 өдөр монгол, солонгос, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Гэрээг тайлбарлахад зөрүү гарвал англи хэл дээрхи эх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫГ
ТӨЛӨӨЛЖ**

**БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС
УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ**